ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад үндэсний геологийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 60 жилийн ойн тусгай дугаар нь мөн МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг – Геологийн асуудлууд сэтгүүл хэвлэгдэж эхэлсний 20 жилийн ойн дугаар юм. 2000 оноос эхлэн хэвлэгдэж эхэлснээс хойш 18 дугаар хэвлэгдээд байгаа Геологийн асуудлууд сэтгүүл өдгөө манай улсад геологийн чиглэлээр гарч байгаа тэргүүлэх сэтгүүлийн нэг болжээ. Энэ хугацаанд Монгол Улсын нийгэм , эдийн засгийн байдал аажмаар өгсөж, уруудсан он жилүүд байсан хэдий ч 20 жил тасралтгүй хэвлэгдсэн нь яах аргагүй бидний амжилтын нэг хэсэг мөн.

1990 оноос хойш Монгол Улс нээлттэй зах зээлийн нийгэм, эдийн засагтай болсон нь шинжлэх ухаан, боловсролд нөлөөлж, монголын эрдэмтэд дэлхийтэй хөл нийлүүлэн алхах болсноор бүтээлүүдээ англи хэл дээрх өндөр түвшний сэтгүүлүүдэд хэвлүүлэх болсон. Энэ хугацаанд олон хүн Япон, БНСУ, АНУ, БНХАУ, Герман, ОХУ, Англи зэрэг орнуудад эрдмийн зэрэг хамгааллаа. Гэсэн хэдий ч тэдгээр өгүүллүүд дотооддоо эрдэм шинжилгээний эргэлтэнд орох нь хангалтгүй байна. Иймд тусгай дугаарыг МУИС-д багшилж байсан болон МУИС-ийг төгссөн геологич эрдэмтдийн гадны өндөр түвшний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллүүдийг дотоодын шинжлэх ухааны эргэлтэнд оруулах, геологичдод түгээх зорилгоор эх өгүүллийг монгол хэл рүү хөрвүүлэн гаргаж байна. Энэ удаад бид хэвлэлийн хэмжээнд баригдан харьцангуй цөөн өгүүллийг гаргаж байгаа боловч цаашид өргөжин олон өгүүлэл ийн эргэлтэнд орох жишиг болно гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ эрчимтэй хөгжиж байгаа зарим чиглэлийн шинэ нэр томъёог манайд нэвтрүүлж, хэвшүүлэх нь чухал байгааг тэмдэглэе.

Тухайн өгүүллүүдийг ишлэхдээ гадны сэтгүүлд хэвлэгдсэн эхийг ишлэж байгаатай адил хэрэглэх хэрэгтэй болохыг редакцийн зөвлөл зөвлөмж болгож байна.

Сэтгүүлийн тусгай дугаар, зохиогчдын өгүүлэлтэй холбоотой санал, зөвлөмж, шүүмж байвал МУИС, ШУС-ийн Геологи, Геофизикийн тэнхимд хаяглан ирүүлэхийг хүсье.